



Г НУБХХ-ИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ
СЕЗИН ШИНАНОГЛУ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26-19-66, Факс: (976-51) 26-61-71, 26-62-86,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn

2012.10.11 № 11734
танай 2012.09.18 -ны № 435 -т


Г Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон болон Монгол улсын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн хэрэгжилтийн үр ашигтай байдлыг дээшлүүлэхтэй холбогдуулан тус яаманд НУБХХ-тэй хамtran гадаадын буцалтгүй тусlamжийн хөрөнгөөр хэрэгждэг төсөл, хөтөлбөрүүдийн Үндэсний захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томиллоо.

Үндэсний төсөл, хөтөлбөрүүдийн захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай тушаалын хуулбарыг хүргүүлж байна.

ЖИЧ: “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент” төслийн Үндэсний захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилоход Үйлдвэр, Хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаал гарах тул түр хойшлогдсон болно.

Хүндэтгэсэн:



Date Rec'd:		12 OCT 2012	
Ref ORG/122/1, Ministry of Nature, Environment and Green Dev.			
Action: FYIA	Info: BB4		
Action Taken:		B/Fwd	

000448



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 10 өдөр

Дугаар Б-16

Улаанбаатар хот

Үндэсний захирал, удирдах
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон болон Монгол Улсын Засгийн газрын буцалтгуй тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийн хэрэгжилтийн үр ашигтай байдлыг дээшлүүлэхтэй холбогдуулан “Гадаадын зээл, тусlamжийг зохицуулах тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, “Засгийн газрын гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн удирдах зөвлөлийн даргаар Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батболд;

2.“Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах хамтарсан хөтөлбөр”-ийн үндэсний захирлаар Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга;

3.“Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг голуудын сав газарт хэрэгжүүлэх нь төсөл”-ийн үндэсний захирлаар Уур амьсгалын өөрчлөлтийг зохицуулах албаны дарга, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан Тусгай элч Д.Дагвадорж, орлогч захиралаар Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Д.Энхбат, удирдах зөвлөлийн даргаар Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батболд нарыг тус тус томилон ажиллуулсугай.

4.“Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн усны нөөцийн нэгдсэн менежмент төсөл”-ийн үндэсний захирлаар Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболд, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар ёсоор;

5.Монгол-Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар ёсоор;

6.“Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх нь” төслийн Удирдах зөвлөлийг гуравдугаар хавсралтаар ёсоор;

1.“Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь 2” төслийн үндэсний захирлаар Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Чулуун, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дөрөвдүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Эдгээр төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгч, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг төслийн үндэсний захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан үндэсний захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 369, төслийн удирдах зөвлөл байгуулах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 03 дугаар сарын 20-ны А-78, төсөл хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 02 дугаар сарын 17-ны А-49, төслийн үндэсний захирал томилох тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б-01, төслийн удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А-91 тоот тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ОЮУН



Байгаль орчин, ногоон хөгжлийн
сайдын 2012 оны 10 дугаар сарын 10-ний
өдрийн 16 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

“Байгаль нуурын сав газрын хил дамнасан
экосистемийн усны нөөцийн нэгдсэн менежмент төсөл”-ийн
удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүн

Ж.Батболд	Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Г.Даваа	Ус цаг уур, орчны хүрээлэнгийн ус судлалын секторын эрхлэгч
Д.Мөнхбат	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хилийн усны асуудал хариуцсан мэргэжилтэн
Ш. Дорж	Сэлэнгэ Аймгийн Байгаль орчин, ногоон хөгжлийн БОАЖГ-ын усны мэргэжилтэн
Б. Бүнчингив	НҮБХХ-ийн Байгаль орчны нэгжийн ахлагч
Г. Тамир	Уул уурхайн яамны уул уурхайн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Байгаль орчин, ногоон хөгжлийн
сайдын 2012 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн
б-16 тоот тушаалын 2 дугаар хавсралт

Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төслийн
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Удирдах зөвлөлийн дарга:

Ой хамгаалал, ойжуулалтыг зохицуулах хэлтсийн
дарга

Гишүүд:

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга

Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны нарийн бичгийн дарга

Геоэкологийн хүрээлэнгийн захирал

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн үндэсний зохицуулагч

Нарийн бичгийн дарга:

Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төсийн зохицуулагч

Байгаль орчин, ногоон хөгжлийн
сайдын 2012 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн
Б-16 тоот тушаалын 3 дугаар хавсралт

“Монгол оронд усны нөөцийн нэгдсэн
менежментийг бэхжүүлэх нь” төслийн удирдах
зөвлөлийн бүрэлдэхүүн

Удирдах зөвлөлийн дарга: Д.Батболд, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: П.Бадамдорж, Усны үндэсний хорооны нарийн бичгийн дарга

Гишүүд:
А.Бакей, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга (өөртэй нь зөвшилцсөнөөр)

Б.Гантулга, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Г.Ганбат, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Сав газрын удирдлагын хэлтсийн дарга

А.Оюунсууд, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Усны нөөцийн хэлтсийн дарга

Ж.Цогтбаатар, Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн захирал (өөртэй нь зөвшилцсөнөөр)


Г.Сарантuya, Ус. цаг уур, орчны хүрээлэнгийн захирал (өөртэй нь зөвшилцсөнөөр)

Р.Самъяа, МУИС-ийн Биологи, биотехнологийн сургуулийн амьтан судлалын тэнхимийн профессор (өөртэй нь зөвшилцсөнөөр)

С.Чулуунхуяг, ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбарын эрхлэгч (өөртэй нь зөвшилцсөнөөр)

Ажиглагч гишүүн:
Onno van den Heuvel, Нидерландын Вант Улсын элчин сайдын яамны Улаанбаатар дахь төлөөлөгч

Байгаль орчин, ногоон хөгжлийн
сайдын 2012 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн
б-16 тоот тушаалтын 4 дүгээр хавсралт



“Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь 2” төслийн
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Удирдах зөвлөлийн дарга: · Б.Тулга, Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд ·

Нарийн бичгийн дарга: Д.Хандармаа, төслийн үндэсний зохицуулагч

Гишүүд: Х.Хишигжаргал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

Н.Дүгэrsүрэн, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Д.Дагвадорж, Уур амьсгалын өөрчлөлтийг зохицуулах албаны дарга,
Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан Тусгай элч

Г.Баясгалан, Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (өөртэй нь зөвшилцсөнөөр)

Д.Ганболд, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн (өөртэй нь зөвшилцсөнөөр)

Томас Эриксон, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн орлогч (өөртэй нь зөвшилцсөнөөр)